



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Есөнбулаг сум,  
Говь-Алтай аймаг, 82099, Утас/Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn,  
Цахим хаяг: www.audit.mn

2024.11.14

№ 396

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймаг, сумдын ИТХ-ын төлөөлөгчийг сонгох 2024 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын тайланд хийсэн аудитын тайланг хүргүүлээ.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

*Г.Гүнжидмаа* Г.ГҮНЖИДМАА



07038056



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/27

Есөнбулаг

Нийцлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.1, 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, нийслэлийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д хийсэн нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон төлбөрийн актыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Сонгуулийн хороонд тус тус хүргүүлсүгэй.

3. Нийцлийн аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Сонгуулийн хорооны дарга Ш.Эрдэнэбатад зөвлөсүгэй.


4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (Цэцэгмаа)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Эрдэнэчимэг)-т даалгасугай.



Г.ГҮНЖИДМАА

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын  
газрын дарга, тэргүүлэх аудиторын  
20.24. оны 11 дугаар сарын 15-ны  
өдрийн 1/27 дугаар тушаалын хавсралт



Аудитаар тогтоосон төлбөрийн акт

д/д	Хариуцагч	Шийдвэрийн			Зөрчлийн утга	Зөрчлийн дүн (мян.төг)
		Төрөл	Огноо	Дугаар		
1	Жаргалан сумын Сонгуулийн хорооны дарга Р.Анхбаяр	Төлбөрийн акт	2024.11.11	01/110	Сумын сонгуулийн хорооны 4 даамалд 1,405.0 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон.	1,405.0
2	Жаргалан сумын Сонгуулийн хорооны дарга Р.Анхбаяр	Төлбөрийн акт	2024.11.11	02/110	Албан хаагчид олгосон сонгуулийн урамшууллаас хувь хүний орлогын албан татварын 2,120.5 мянган төгрөгийг шилжүүлээгүй.	2,120.5
3	Цээл сумын Сонгуулийн хорооны дарга Ц.Батбаяр	Төлбөрийн акт	2024.11.11	03/110	Сонгуулийн дахин санал хураалтаар ажилласан албан хаагчдад олгосон урамшууллаас 288.9 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг шилжүүлээгүй.	288.9
<b>НИЙТ</b>						<b>3,814.4</b>

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ  
ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/15-ШТА-НА

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын  
газар

Дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа  
Утас: 70483413

Цахим хаяг: Gunjidmaag@audit.gov.mn  
Аудитын менежер Д.Эрдэнэчимэг  
Утас: 70484055

Цахим хаяг: Erdenechimegd@audit.gov.mn  
Ахлах аудитор Б.Цэцэгмаа

Цахим хаяг: Tsetsegmaab@audit.gov.mn  
Ахлах аудитор М.Атарцэцэг

Цахим хаяг: Atartsetsegm@audit.gov.mn  
Аудитор Н.Гэрэлмаа

Цахим хаяг: Gerelmaan@audit.gov.mn

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН  
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**

Агуулга	
<b>Товчилсон үг</b> .....	2
<b>Хүснэгтийн товъёг</b> .....	2
<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b> .....	3
<b>Үндсэн мэдээлэл</b> .....	4
1. Аймгийн сонгуулийн хороо сонгууль зохион байгуулахтай холбоотой төсвийг сумдад зардлын гүйцэтгэлээр хуваарилсан байна. ....	6
2. Аймаг, сумдын Сонгуулийн хорооны зардлын тайланг заавар аргачлалд тусгасан зардлын ангиллаар тайлагнаагүй байна.....	6
3. Сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлын гүйцэтгэлд тавих төрийн сангийн хяналт хангалтгүй байна.....	6
4. Аймгийн Сонгуулийн хороо нь сумдын Сонгуулийн хорооны зарцуулаагүй үлдэгдэл болох 3,835.6 мянган төгрөгийг Сонгуулийн Ерөнхий хорооны төрийн санд байршиж буй бүртгэлийн дансанд төвлөрүүлсэн байна.....	6
<b>ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:</b> .....	7
Тэмдэглэл.....	8

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН  
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

Товчилсон үг

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ЦГ	Цагдаагийн газар
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар
ҮСХ	Үндэсний Статистикийн хороо
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчийн Хурал
АСХ	Аймгийн Сонгуулийн хороо
ССХ	Сумын Сонгуулийн хороо

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Санхүүжилт	4

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**

<b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>	<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b> Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/152, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162 дугаар тушаалын дагуу хийж гүйцэтгэлээ.
<b>Аудитын зорилт</b>	Аймаг, нийслэлийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Дээрх зорилгын хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"><li>✓ Аймаг, сумдын Хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн төсвийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;</li><li>✓ Аймаг, сумдын Хурлын 2024 оны сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх</li></ul>
<b>Аудитын хамарсан хүрээ</b>	Аудитад аймаг, сумдын Сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газрыг хамруулсан.
<b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b>	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС 100, АДБОУС-400, АДБОУС-4000, АДБОУС-4200-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817:2020 Нийцлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.
<b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</b>	Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Цэцэгмаа, М.Атарцэцэг, аудитор Н.Гэрэлмаа нар гүйцэтгэв. Аудитын гүйцэтгэх үе шатны талбарын ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр хүртэл гүйцэтгэж, нэгтгэлийг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр хийж аудитын тайланг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.
<b>Хүндрэл бэрхшээл</b>	Жаргалан, Цээл, Халиун, Цогт, Эрдэнэ, Тонхил сумын Сонгуулийн хороод нь 2024 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр хүртэл зарлагын гүйлгээ хийсэн, аймгийн Сонгуулийн хороо нэгтгэсэн тайланг эцэслээгүйгээс аудит хийхэд хүндрэлтэй байлаа.

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**

**Үндсэн мэдээлэл**

Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны 2024 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор аймгийн Сонгуулийн хороог 7 хүний бүрэлдэхүүнтэй, Сонгуулийн Ерөнхий хорооны 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 206 дугаар тогтоолоор аймгийн Сонгуулийн хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн багийг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулж, хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Сонгуулийн Ерөнхий хорооноос 1,266,420.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт №1 Санхүүжилт, мянган төгрөг

№	Байгууллагын нэр	Санхүүжилт	Гүйцэтгэл	Хэмнэлт
1	Аймгийн Сонгуулийн хороо	1,154,666.9	1,150,831.3	3,835.6
2	Улсын бүртгэлийн хэлтэс	80,407.9	80,407.9	-
3	Цагдаагийн газар	31,346.0	31,346.0	-
	Дүн	1,266,420.8	1,262,585.2	3,835.6

Эх сурвалж: Аймгийн Сонгуулийн хороо, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс

**БҮЛЭГ 1. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТой ТӨСВИЙГ СУМДАД ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛЭЭР ХУВААРИЛСАН БАЙНА.**

- 1.1 Аймгийн Сонгуулийн хороонд аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс 1,154,666.9 мянган төгрөг, Улсын бүртгэлийн хэлтэст 80,407.9 мянган төгрөг, Цагдаагийн газарт 31,346.0 мянган төгрөг нийт 1,266,420.8 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна.
- 1.2 Аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/68 дугаар тушаал болон Сонгуулийн Ерөнхий хорооны Тамгын газрын 2024 оны 09 дүгээр сарын 3/834, 3/852, 3/893, 3/909, 10 дугаар сарын 3/940 дугаар төсвийн зарцуулалтын тухай тайлбар, санхүүжилтийн хуваарийн дагуу аймаг, сумдын Сонгуулийн хороодод төсвийг хуваарилжээ
- 1.3 Аймгийн Сонгуулийн хороо нь улсын төсвөөс олгосон санхүүжилтийн 83.0 хувь буюу 964,637.7 мянган төгрөгийг сумдад хуваарилсан байна.
- 1.4 Сонгуулийн зардлын төсвийг тооцож олгохдоо нэгж байгууллагуудаас төсвийн төсөлд санал, тооцоолол судалгаа аваагүй байна.
- 1.5 Сонгуулийн зардлын санхүүжилтийг төрийн сан дахь бүртгэлийн данс, нэмэлт дансаар олгож, төрийн сан хяналт хэрэгжүүлсэн байна.
- 1.6 Сонгууль зохион байгуулахад аймгийн 1 хороонд 7, сумын 18 хороонд 126, Сонгуулийн 88 хэсгийн хороонд 754, мэдээлэл технологийн багт 7, сумдын даамал, нөөц даамал 107, гэрээт 2, тагнуулын 2 ажилтан, улсын бүртгэлийн 71 итгэмжлэгдсэн төлөөлөгч, 142 цагдаагийн албан хаагч, нийт 1218 ажилтан албан хаагчийн бүрэлдэхүүн Сонгуулийн хороо, хэсгийн санал авах байранд ажилласан ба Сонгуулийн үйл ажиллагаанд холбогдох шийдвэрийн дагуу томилогдсон хүний нөөцийг бүрэн ашиглажээ.
- 1.7 Сонгуулийн Ерөнхий хорооноос санхүүжилт хуваарилж олгохдоо холбогдох задаргаа тайлбар, зөвлөмж өгч ажилласан байна.
- 1.8 Сонгуулийн Ерөнхий хорооноос ирүүлсэн зөвлөмж аргачлалын дагуу тооцоход сумын Сонгуулийн хороо, хэсгийн хороодод хуваарилбал зохих 21,092.5 мянган төгрөгийн төсвийг хуваарилаагүй байна.

**БҮЛЭГ 2. СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ГАРСАН ЗАРДЛЫГ  
ГҮЙЦЭТГЭЛЭЭР ЗАРЦУУЛСАН БОЛОВЧ АНХАН ШАТНЫ БАРИМТЫН БҮРДЭЛ  
ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

- 2.1 Улсын төсвөөс аймагт хуваарилсан төсвийн 17 хувь буюу 190,029.0 мянган төгрөгийг аймгийн Сонгуулийн хороо, 83 хувь буюу 964,637.7 мянган төгрөгийг сумдын Сонгуулийн хороо зарцуулсан байна.
- 2.2 Сонгуулийн зардлын гүйцэтгэлийн 733,990.4 мянган төгрөг буюу 64 хувь Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, 96,656.0 мянган төгрөг буюу 8 хувь мэдээлэл технологийн гишүүд, даамлын урамшуулал нийгмийн даатгалын шимтгэл, 78,062.0 мянган төгрөг буюу 7 хувь унааны зардал, 242,122.9 мянган төгрөг буюу 21 хувь нь бусад 19 төрлийн зардалд тус тус зарцуулсан байна.
- 2.3 Сумдын Сонгуулийн хороодоос зардлын тайлан авч аймгийн Сонгуулийн хорооны нягтлан бодогч нэгтгээгүйгээс сумдын гүйлгээ дуусаагүй, зардлын тайлан өөр, өөр маягтаар гаргасан байна.
- 2.4 Жаргалан, Цогт сумын Сонгуулийн хороо зардлын тайлан гаргаагүй, бусад сумдын Сонгуулийн хороо зардлын тайлан гаргасан боловч Сонгуулийн Ерөнхий хорооноос ирүүлсэн зардлын ангиллыг баримтлаагүй байна.
- 2.5 Аудитаар нэгтгэсэн зардлын тайланд дараах залруулга хийлээ. Үүнд:
- Улсын төсвөөс санхүүжүүлсэн сонгуулийн зардлын нэгтгэсэн тайлан ирүүлснээс хойш аймаг, сумдын дансны гүйлгээ 2024 оны 11 дүгээр арын 07-ны өдрийг хүртэл үргэлжилсэн ба аудитын хугацаанд нийт 6,947.4 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна.
  - Сумдын Сонгуулийн хорооны нягтлан бодогчид тайлан ирүүлэх заавар аргачлалын дагуу хуваарилсан зардал тус бүрээр тайлан бэлтгээгүйгээс 505,632.4 мянган төгрөгийг бодит гүйцэтгэлээр холбогдох зардлын ангиллаар залруулан тайлагнуулсан.
  - Аудитын явцад 16,086.8 мянган төгрөгийн анхан шатны баримтыг нэмэлтээр гаргаж ирүүлсэн.
- 2.6 Улсын бүртгэлийн хэлтэст сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор урамшуулал, албан томилолт, сургалт, унаа, бичиг хэргийн зардалд зарцуулах 80,407.9 мянган төгрөгийн санхүүжилт тус байгууллагын төрийн сан дахь нэмэлт төсвийн дансанд төвлөрүүлж бараа үйлчилгээний бусад зардал ангилалд тайлагнасан байна.
- 2.7 Цагдаагийн газарт олгосон шуудан холбоо, шатахуун, хоолны зардалд зарцуулах 31,346.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус байгууллагын төрийн сан дахь нэмэлт төсвийн дансанд төвлөрүүлж зарцуулалтыг зохих зардлын зүйл тус бүрээр тайлагнасан байна.
- 2.8 Аймгийн Сонгуулийн хорооны зардлын зарцуулалтыг дарга, нягтлан бодогч, сумдын Сонгуулийн хорооны зарцуулалтыг сумдын Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нар харьяа төрийн сандаа гарын үсгийн баталгаа гарган төрийн сангийн хяналттайгаар зарцуулалт хийсэн боловч аудитаар материаллаг дүнтэй алдаа, зөрчил илэрч байгаа нь шат шатны хяналт хангалтгүй байна.

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**

**Илрүүлэлт:**

- Улсын төсвөөс санхүүжүүлсэн сонгуулийн зардлын төсвөөс 9,682.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн. (Аймгийн Сонгуулийн хороо)
- Улсын төсвөөс санхүүжүүлсэн сонгуулийн зардлын төсвөөс 3,027.0 мянган төгрөгөөр автомашинд засвар үйлчилгээ хийсэн. (Аймгийн Сонгуулийн хороо)
- Улсын төсвөөс санхүүжүүлсэн сонгуулийн зардлын төсвөөс 701.6 мянган төгрөгийн хоолны зардлыг давхардуулан гаргасан байна. (Аймгийн Сонгуулийн хороо)
- Сонгуулийн хорооны нягтлан бодогчид тооцооллын алдаа гаргаснаас 2,409.4 мянган төгрөгийн Хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй, шилжүүлээгүй (Жаргалан, Цээл сумдын Сонгуулийн хороо)
- Сумын Сонгуулийн хорооны нягтлан бодогч сонгуульд ажилласан даамлуудад 1,405.0 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон. (Жаргалан сумын Сонгуулийн хороо)

**Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:**

1. Аймгийн сонгуулийн хороо сонгууль зохион байгуулахтай холбоотой төсвийг сумдад зардлын гүйцэтгэлээр хуваарилсан байна.
2. Аймаг, сумдын Сонгуулийн хорооны зардлын тайланг заавар аргачлалд тусгасан зардлын ангиллаар тайлагнаагүй байна.
3. Сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлын гүйцэтгэлд тавих төрийн сангийн хяналт хангалтгүй байна.
4. Аймгийн Сонгуулийн хороо нь сумдын Сонгуулийн хорооны зарцуулаагүй үлдэгдэл болох 3,835.6 мянган төгрөгийг Сонгуулийн Ерөнхий хорооны төрийн санд байршиж буй бүртгэлийн дансанд төвлөрүүлсэн байна.

**ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: ХУВААРИЛСАН ТӨСӨВ НЬ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛЭЭС ИЛҮҮ БАЙГААГААС ЗОРИУЛАЛТ БУС ЗАРЦУУЛАЛТ ГАРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛСЭН БАЙНА.**

Аудитаар 3,814.4 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс аймгийн Сонгуулийн хороонд 3,814.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, нэгтгэсэн тайланд тусгуулах 2 зөвлөмжийг саналыг Үндэсний аудитын газарт хүргүүллээ.

**ТӨЛБӨРИЙН АКТ:**

**АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНД:**

Төсвөөс урамшуулал олгосон 1,405.0 мянган төгрөгийг Жаргалан сумын Сонгуулийн хорооны дансанд, дутуу шилжүүлсэн Хувь хүний орлогын албан татвар болох 2,120.5 мянган төгрөгийг Жаргалан, Цээл сумын төсвийн орлогын дансанд тус тус төвлөрүүлэх.

**ЗӨВЛӨМЖ:**

Аудитаар илэрсэн зөрчлийг нэгтгэсэн тайланд тусгуулан, Сонгуулийн Ерөнхий хороонд дараах зөвлөмж хүргүүлэх саналыг уламжилж байна.

1. Сумдын Сонгуулийн хороо, хэсгийн хороодод хуваарилах төсвийг Сонгуулийн Ерөнхий хорооноос ирүүлсэн заавар, чиглэлийн дагуу тооцоогүй байна.
2. Сонгуулийн Ерөнхий хорооноос аймагт хуваарилсан төсөв нь бодит гүйцэтгэлээс илүү байгаагаас зориулалт бус зарцуулалт гарах нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал: Тус төсвөөс 9,682.5 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн, 3,027.0 мянган төгрөгөөр автомашинд засвар хийлгүүлсэн, 701.6 мянган төгрөгийн хоолны зардлыг давхардуулан гаргасан байна.

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН  
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
СОНГУУЛИЙН ХОРОО

Жинст баг, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82093

Утас: 7048-3002

Цахым шуудан: songuuliin-horoo@govi-altai.gov.mn

2024.11.08 № 72

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах аймгийн Сонгуулийн хорооны санхүүгийн зардлын тайланд аудитын хэлэлцүүлэг хийсний үр дүнд нэмэлт баримтуудыг хавсаргаж байгааг харгалзан үзэж, зохих шийдвэрийг гаргаж өгнө үү.

ДАРГА



Ш.ЭРДЭНЭБАТ

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН  
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
СОНГУУЛИЙН ХОРОО

Жинст баг, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82093

Утас: 7048-3002

Цахим шуудан: songuliin-horoo@govi-altai.gov.mn

2024.11.14 № 93

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санхүүгийн  
зардлын тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн  
зөвшөөрч байна.

Шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана.

ДАРГА



Ш.ЭРДЭНЭБАТ

№	Санал	Хариу тайлбар
1	Шатахуун зарцуулалтын нэмэлт баримт материал болон Сонгуулийн ажилд явж байгаад осолдсон автомашины сэлбэг засварын нэмэлт баримт материалыг харгалзан үзнэ үү	Нэмэлтээр ирүүлсэн анхан шатны баримтыг дахин үзэж бодит байдлыг үнэлэхэд шаардлага хангаж байгаа тул аудитын багийн зүгээс саналыг хүлээн авсан.

Тэмдэглэл

.....  
.....

